

МОНГОЛ-ОРОСЫН ХАМТАРСАН МЭДЭГДЭЛ

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Д.А.Медведевийн урилгаар 2011 оны тавдугаар сарын 31-нээс зургаадугаар сарын 3-ны өдрүүдэд Оросын Холбооны Улсад албан ёсоор айлчлав. Ц.Элбэгдорж, Д.А.Медведев нар 2011 оны тавдугаар сарын 31-ний өдөр Москвад ганцаарчилан уулзаж, өргөтгөсөн хэлэлцээ хийв. Ц.Элбэгдорж Оросын Холбооны Улсын Засгийн газрын дарга В.В.Путин, Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Төрийн Думийн дарга Б.В.Грызлов, Оросын Холбооны Улсын Холбооны Хурлын Холбооны Зөвлөлийн нэгдүгээр орлогч дарга А.П.Торшин нартай уулзав.

Ц.Элбэгдорж мөн Санкт-Петербург, Элстэй хотуудад зочиллоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч Монголын үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100 жил, Монгол Улс, Орос Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 90 жилийн ойн жил Оросын Холбооны Улсад айлчлал хийсэн нь Монгол, Оросын найрамдал, хамтын ажиллагааны залгамж чанар, тэдгээрийн өнгөрсөн болон өнөөгийн уялдаа холбоог тодруулж өглөө.

Ц.Элбэгдорж, Д.А.Медведев нар 2009 оны наймдугаар сард Улаанбаатар хотноо дээд хэмжээнд хийсэн өмнөх уулзалтаасаа хойшхи хоёр талын хамтын ажиллагааны явцыг олон арван жилийн хугацаанд уламжлал болон тогтсон Монгол-Оросын сайн хөршийн харилцаа, харилцан ойлголцол, итгэлцлийн үзэл санааны дагуу нягтлан хэлэлцэж, олон улсын болон бүс нутгийн зарим асуудлаар санал солилцов.

Хоёр улсын төрийн тэргүүн нар 2009 оны наймдугаар сарын 25-ны өдөр тэдний гарын үсэг зурсан Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглалыг амьдралд хэрэгжүүлэх талаар идэвхтэй хамтран ажиллаж дорвитой, нааштай үр дүнд хүрснийг сэтгэл ханамжтай тэмдэглэв. Энэ Тунхаглал цаашид ч Монгол-Оросын харилцааг цогцод нь хөгжүүлэхэд чиглүүлэгч, зохион байгуулагч үүрэг гүйцэтгэнэ гэдэгт хоёр тал итгэл төгс байгаагаа илэрхийлэв.

Монгол Улс, Оросын Холбооны Улс нь улс төрийн яриа хэлцээг эрчимтэй, тогтмол явуулж, энэ хүрээнд хоёр улсын төрийн болон засгийн газрын тэргүүн, парламент, аюулгүй байдлын зөвлөл, яам, газар, улс төрийн нам, аж ахуйн болон олон нийтийн байгууллага, бүс нутгийн удирдлагуудын биечилсэн уулзалт хийж ирэв. Ерөнхийлөгч нар манай орнуудын болон Ази тив, дэлхий дахины өмнө нээгдэж байгаа шинэ боломж, тулгаран гарч ирж буй аюул занал, сорилтуудын бүхий л цар хүрээнд ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд хоёр талын харилцан ажиллагааны янз бүрийн чиглэлээр айлчлал, солилцооны өндөр түвшинг цаашид ч хадгалах болон батлан хамгаалах чадвар, аюулгүй байдлаа бэхжүүлэхэд бие биедээ туслалцаа үзүүлж байхаар тохиролцов.

Ц.Элбэгдорж, Д.А.Медведев нар энэ оны гурав, дөрөвдүгээр сард Монгол-Оросын багийн сансрын нислэгийн 30 жил, жолоодлогот сансар судлалын 50 жилийн ойн баярыг хамтран зохион байгуулсныг чухалчлан тэмдэглээд, энэ оны арван нэгдүгээр сард тохиох Монгол Улс, Орос Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 90 жилийн ойд зориулсан цогц арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэхийг засгийн газрууддаа даалгах болов.

Хоёр талын бараа эргэлтийн хэмжээ түргэн сэргэж, хямралын өмнөх түвшинд хүрснийг Ерөнхийлөгч нар өндрөөр үнэллээ. Энэ нь хоёр орны эрчимтэй хөгжиж байгаа эдийн засаг ихээхэн хүч чадавхитай болохыг, хоёр тал тогтвортой, уламжлалт харилцаандаа тулгуурлан энэхүү чадавхийг бүх талаар тууштай хөгжүүлэхээр эрмэлзэлтэй байгааг нотлон харуулж байна гэж үзэв.

Хоёр улсын төрийн тэргүүн нар Монгол-Оросын харилцан ажиллагааны тодорхой төслүүдийг хэрэгжүүлэхэд Монгол-Оросын Засгийн газар хоорондын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны комисс ихээхэн үүрэг гүйцэтгэж байгааг цохон тэмдэглэв. Монгол-Оросын худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг 2011-2015 онд хөгжүүлэх хөтөлбөр, бусад гол баримт бичгүүдийг энэхүү комиссын ивээл дор амжилттай боловсруулж, хэрэгжүүлж байгаа билээ.

Талууд ЕвроАзийн Эдийн засгийн хамтын нийгэмлэгийн хүрээн дэх Гаалийн холбооны гишүүн орнууд болон Монгол Улсын хооронд чөлөөт худалдааны тухай хэлэлцээр байгуулах асуудлаар хамтарсан судалгааны хэсэг байгуулах тохиролцоонд хүрснийг сэтгэл ханамжтай хүлээн авлаа. Энэхүү хэлэлцээрийг байгуулах нь хоёр талын худалдааны хэмжээг нэмэгдүүлэх, түүний тэнцвэржилтийг илүү хангах, эдийн засгийн бусад салбарт улам нягт хамтран ажиллахад тус дөхөм болно гэж Монгол Улс, Оросын Холбооны Улс үзэж байна.

2010 оны арван нэгдүгээр сард Монгол-Оросын ба Орос-Монголын ажил хэргийн зөвлөлүүд байгуулагдсаныг Ц.Элбэгдорж, Д.А.Медведев нар сайшаав. Хоёр орны худалдаа, аж үйлдвэрийн танхим, ажил хэргийн зөвлөл болон бизнес эрхлэгчдийн бусад байгууллагын боломжийг ашиглах нь ажил хэргийн хүрээнд төлөөлөгчдийн солилцоог өргөтгөх, жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг хоёр талын харилцаанд татан оруулах, хоёр оронд болж байгаа үзэсгэлэн-яармагийн арга хэмжээ, семинар, симпозиумд Монгол, Оросын компаниудыг оролцуулах, хэгийн ирээдүйтэй түншлэлийн чиглэлийг тодруулах, хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх зэргээр худалдаа-эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх нэмэлт хүчин зүйл болохыг тэмдэглэв.

Хил орчмын болон бүс нутаг хоорондын хэлхээ холбоо нь Монгол-Оросын харилцаанд жинтэй үүрэг гүйцэтгэсээр байгааг Ерөнхийлөгч нар тэмдэглэв. Хоёр талын бараа эргэлтийн 70 хувь, соёл-хүмүүнлэгийн

солилцоо, хүмүүс хоорондын харилцааны тэн хагасаас илүү нь энэхүү харилцаанд ногдож байна. Москва хотноо 2010 оны арван хоёрдугаар сард гарын үсэг зурсан Монгол Улс, Оросын Холбооны Улсын бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааг 2011-2012 онд эрчимжүүлэхэд нэн тааламжтай эрх зүй, худалдаа-эдийн засгийн болон бусад нөхцлийг бүрдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээн дэх бүс нутаг хоорондын хамтын ажиллагаа нь хоёр талын түншлэлд шинэ түлхэц өгнө гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлэв.

Монголын шилжих рублийн өрийн асуудлыг 2010 оны арван хоёрдугаар сард эцэслэн зохицуулсан нь харилцан ашигтай төслүүдийг улсын шугамаар зээлжүүлэн, санхүүгийн хүрээнд чанарын шинэ хамтын ажиллагааны боломжийг нээж буйг Ц.Элбэгдорж, Д.А.Медведев нар цохон тэмдэглэв.

Талууд худалдаа-эдийн засгийн харилцан ажиллагааныхаа дэд бүтэц, механизмыг сайжруулахад шаардлагатай алхам хийж, өөрийн нутаг дэвсгэрт ажил хэрэгч уур амьсгал, хөрөнгө оруулалтын орчныг боловсронгуй болгох, хоёр талын худалдаанд байгаа асуудал, түүний дотор гуравдагч орны зах зээлд бүтээгдэхүүнээ гаргахад дэмжлэг үзүүлэх асуудлыг харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан үр бүтээлтэй шийдвэрлэхийг зорьж байгаагаа илэрхийлэв.

Монгол-Оросын худалдааны нөхцлийг цаашид сайжруулахад тус нэмэр болно гэж үзэж Оросын Холбооны Улсыг Дэлхийн худалдааны байгууллагад даруй элсүүлэхийг дэмжиж байгаагаа Монгол Улс дахин мэдэгдэв.

Хоёр орны Төрийн тэргүүн нар Монгол-Оросын хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааны зарим томоохон төсөл, түүний дотор Дорнодын бүс дэх ураны хүдрийн геологи хайгуул, олборлох, боловсруулах ажилд Оросын корпорациудыг оролцуулах асуудалд ихээхэн анхаарал хандуулав.

Талууд Монголын төмөр замын дэд бүтцийг байгуулах, шинэчлэх, Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг санхүүгийн хувьд бэхжүүлэн шинэтгэх, улмаар Монгол-Оросын төмөр замын салбарын хамтын ажиллагааг бүхэлд нь сайжруулах, түүний дотор Монголын баялгийн шинэ нөөцийг ашиглах, шинэ төмөр зам тавихтай холбоотой асуудлыг хамтарсан төслүүдийн хүрээнд нягт уялдаатай шийдвэрлэхийг зорьж байгаагаа мэдэгдэв.

Монгол Улс газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ үндсэнд нь Оросын Холбооны Улсаас импортоор хангаж буйг харгалзан түүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах боломжтой арга замыг судалж үзэхийг холбогдох байгууллагуудад үүрэг болгохоор Талууд тохиролцов.

Шүлхий болон малын бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын 22 цэгийг Монгол Улсад зохион байгуулах бэлтгэл арга хэмжээ дууссан тухайгаа Оросын Тал мэдээлэв. Оросын Холбооны Улсад бүтээгдэхүүн нийлүүлэх үүднээс мах боловсруулах үйлдвэрүүдийн аттестатчлалыг Монгол Улсын нутаг дэвсгэрт Оросын хөдөө аж ахуйн хяналтын алба (Россельхознадзор) зохион байгуулахад чиглэсэн хамтын ажиллагааг үргэлжлүүлэхээ Талууд мэдэгдэв.

Хүрээлэн буй орчныг хамгаалах салбарын хамтын ажиллагааг Талууд нааштай үнэлэв. Ц.Элбэгдоржийн айлчлалын үеэр “Увс нуурын хотгор” хил дамнасан дархан газар байгуулах тухай засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурсан нь энэхүү хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал алхам болов.

Үйлдвэрлэлийн осол, байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах талаар хамтран ажиллах тухай хоёр талын засгийн газар хоорондын 1995 оны хэлэлцээрийн хүрээнд харилцан ажиллагаа өргөжсөөр байгааг Талууд тэмдэглэв. Ой, хээрийн том хэмжээний түймрийн үед Монголын Тал хүсэлт гаргасан тохиолдолд Орос Улсын ОБЯ-ны нисэх хүчнийг ашиглан түймрийг унтраахад тусламж үзүүлэхэд бэлэн байгаагаа Оросын Тал илэрхийлэв.

Монгол-Оросын улсын хил дээрх шалган нэвтрүүлэх боомтуудын үр ашигтай ажиллагааг хангах зорилгоор эдийн засаг, нийгмийн ач холбогдол бүхий боомтуудыг хөгжүүлэхэд хүчин чармайлтаа төвлөрүүлэхийг хоёр орны эрх бүхий байгууллагуудад үүрэг болгохоор Ерөнхийлөгч нар тохиролцов. Үүний тулд засгийн газар хоорондын холбогдох шинэ хэлэлцээрүүдийг боловсруулж, байгуулах нь зүйтэй гэж үзэв.

Монгол Улс, Оросын Холбооны Улс нэг Талын нутаг дэвсгэр дээрх нөгөө Талын үл хөдлөх эд хөрөнгө, түүний дотор газартай холбоотой асуудлыг зохицуулах ажлыг идэвхжүүлэхийг зорих болно.

Ц.Элбэгдорж, Д.А.Медведев нар юуны өмнө Талуудын нутаг дэвсгэр дээр цэргийн хамтарсан хээрийн сургууль хийж, Монголын цэргийн албан хаагч болон кадетуудыг Оросын Холбооны Улсын тухайн чиглэлийн сургуулиудад суралцуулж, давтан сургаж, Оросын үйлдвэрийн орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникийг Монголд нийлүүлж, цэрэг-техникийн хамтын ажиллагааг чанарын шинэ түвшинд гаргахад шаардагдах баримт бичгүүдийг боловсруулах зэрэг чиглэлээр хөгжүүлж байгаа хоёр орны цэргийн болон цэрэг-техникийн хамтын ажиллагаанд өндөр үнэлэлт өгөв. Энэ ажил цаашид ч үргэлжлэх болно.

Соёлын салбар дахь олон жилийн хэлхээ холбоо нь хоёр орны ард түмний ойлголцол, найрсаг харилцааг цаашид бэхжүүлэх чухал хэрэглүүр болохыг Талууд тэмдэглэлээ. Ази, Номхон далайн бүс нутаг дахь оросын соёлын томоохон байгууллагуудын нэг болох Улаанбаатар дахь Оросын

шинжлэх ухаан, соёлын төв (ОШУСТ)-ийн 35 жилийн ойг тэмдэглэхэд олон нийтийн зохих анхаарлыг хандуулахаар Ерөнхийлөгч нар тохиров.

Хоёр улсын Төрийн тэргүүн нар Монгол Улсад орос хэлийг өргөнөөр, тухайлбал ОШУСТ, “Оросын ертөнц” сангийн төвүүд, Оросын ерөнхий боловсролын сургуулиудын салбарт тулгуурлан сурах, түүнчлэн Орос Улсад амжилттай ажиллаж буй монгол судлалын үндэсний төвүүдэд тулгуурлан монгол хэл, соёлыг судлахыг тууштай хөхиүлэн дэмжихээ нотлов. Талууд монгол, орос хэлний их толь бичиг гаргахаар бэлтгэж буй ажлыг өндөр үнэлэв.

Холбооны төсвөөс санхүүжүүлэн Оросын их дээд сургуульд тэтгэлэгтэй суралцуулах монгол оюутан, аспирант, судлаачдын тоог төлөвлөгөөтэйгээр нэмэгдүүлж байгаатай холбогдуулан Ц.Элбэгдорж Д.А.Медведевт чин сэтгэлийн талархал илэрхийлэв. Ийнхүү суралцагчдын тоо 2011-2012 оны хичээлийн жилд 230-аас 300 болж нэмэгдэх болно.

Монгол, Оросын Засгийн газар хоорондын худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны комиссын хүрээнд боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах дэд комиссыг ойрын хугацаанд тусгайлан байгуулах нь энэ салбарын харилцан ажиллагааг чанарын шинэ түвшинд гаргах таатай нөхцлийг бүрдүүлнэ хэмээн Талууд үзэв.

Ерөнхийлөгч нар Монгол, Оросын байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаа, түүний дотор нүүдэлчдийн түүх, соёлын өвийг судлах, хамгаалах ажлын чухлыг тэмдэглэв. Үүнтэй холбогдуулан Шинжлэх ухааны хамтын ажиллагааны тухай Монголын Шинжлэх ухааны академи, Оросын Шинжлэх ухааны академи хоорондын хэлэлцээрийн хүрээнд хийсэн ажлын үр дүнг Талууд сайшаав.

Хоёр улсын Төрийн тэргүүн нар олон улсын өнөөгийн нөхцөл байдлын голлох асуудлуудыг хэлэлцээд, олон улсын өвөрмөц нийтлэг бүтэц болох Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний Аюулгүйн зөвлөл олон улсын эрх зүйн хэм хэмжээг сахиулах, даян дэлхийн болон бүс нутгийн энх тайван, аюулгүй байдлыг хангах, бүх улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн амин чухал нөхцлийг бүрдүүлэх зэрэгт орлуулашгүй үүрэгтэйг цохон тэмдэглэв. Монгол Улс, Оросын Холбооны Улс нь НҮБ, түүний төрөлжсөн байгууллагууд, тухайлбал Мянганы хөгжлийн 2015 хүртэлх зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг цаашид ч өргөжүүлэн гүнзгийрүүлэхэд бэлэн байна.

Монгол Улс, Оросын Холбооны Улс нь шинэ сорилт, аюул заналхийлэл, тухайлбал олон улсын терроризм, хүний наймаа, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хууль бус эргэлтийг цаашид ч хамтын хүчин чармайлтаар эсэргүүцэх болно.

Монголын Тал дэлхийн санхүү, эдийн засгийн тогтолцоог шинэтгэх үйл явцад “Хорийн бүлэг” чухал үүрэгтэйг тэмдэглээд, зах зээлийн эдийн засаг нь бүрдэж байгаа улс орнуудын болон хөгжиж буй орнуудын эрх ашгийг илэрхийлж байгааг Оросын Холбооны Улс болон БРИКС-ийн бусад оролцогч орны үйл ажиллагааг нааштай үнэлэв.

Бүс нутагтаа болон олон улсын талбарт Монгол Улсын явуулж байгаа улам бүр идэвх санаачлагатай бодлогыг Оросын Тал өндрөөр үнэлэв. Улаанбаатар болон Москва цаашид ч олон улсын харилцааны хүрээнд бие биедээ дэмжлэг туслалцаа үзүүлж, гадаад бодлогын асуудлаар тогтмол зөвлөлдөж, олон талт голлох байгууллага, чуулга уулзалтын хүрээнд хийх алхмаа уялдуулж байх болно.

Цөмийн зэвсэггүй статусынхаа баталгааг бэхжүүлэх талаар Монгол Улсын гаргасан саналыг Оросын Тал “цөмийн зэвсэгтэй тав”-ын бусад улстай хамт үргэлжлүүлэн судлахад бэлэн байгаагаа илэрхийлэв.

Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ) нь Төв Азийн аюулгүй байдлыг хангаж, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх үр нөлөөтэй хүчин зүйл болж, олон улсын харилцаанд бүрэлдэж буй олон төвт тогтолцооны нэгэн хэсэг болон төлөвшсөнийг тус байгууллагын 10 жилийн ойн жил Монгол Улс, Оросын Холбооны Улс сэтгэл ханамжтай тэмдэглэв. Монгол Улс ШХАБ-ын хүрээн дэх эдийн засгийн хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, түүний дотор ШХАБ-ын Ажил хэргийн зөвлөлийн шугамаар хамтран ажиллах эрмэлзэл төгс байгааг Оросын Тал сайшаав.

Талууд Ази, Номхон далайн бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг бэхжүүлэхийн чухлыг нотлов. 2010 оны есдүгээр сард Бээжин хотноо дэвшүүлсэн бөгөөд аюулгүй байдлын хуваагдашгүй зарчмыг бататгах, бүс нутгийн янз бүрийн улс орны эрх ашгийн тэнцвэрийг хангаж, аюулгүй, тогтвортой байдал, хөгжлийг хангах бүс нутгийн түншлэлийн бүтцүүдийн сүлжээг бий болгоход чиглэсэн Орос, Хятадын санаачлагын ач холбогдлыг Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж онцлон тэмдэглэв. Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн үйл ажиллагаанд оролцох Монгол Улсын эрмэлзлийг Оросын Тал тууштай дэмжиж байна.

Монголын Тал Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагад нэгдэн орох бодолтой байгаагаа Оросын Талд мэдээлэв. Оросын Тал Монголын энэ санаачлагыг анхааралтай авч үзэхэд бэлэн байгаагаа илэрхийлэв.

Солонгосын байдлыг улс төрийн аргаар зохицуулахаас өөр сонголтгүй бөгөөд Солонгосын хойгийн цөмийн асуудлыг шийдвэрлэх зургаан талт хэлэлцээг сэргээх нөхцлийг сонирхогч орнуудын зүгээс бүрдүүлэх шаардлагатай гэж үзэж байгаагаа Ерөнхийлөгч нар илэрхийлэв.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нар 2011 оны гуравдугаар сарын 11-ний өдөр болсон байгаль - техноген сүйрлийн үр дагаврыг даван туулахаар Япон улс чармайж байгаа энэ хүнд үед Японы Засгийн газар, ард түмэнтэй эв санааны нэгдэлтэй байгаа илэрхийлж, тус оронд боломжтой бүхий л туслалцаа үзүүлэхэд бэлэн байгаагаа нотлов.

Транзит тээврийн салбарт хамтран ажиллах асуудлаар 2003 оны наймдугаар сард Алматы хотод болсон Далайд гарцгүй хөгжиж байгаа орон, хөгжиж буй транзит орон, донор орнуудын сайд нарын болон санхүүжилт, хөгжлийн асуудал эрхэлсэн олон улсын байгууллагын төлөөлөгчдийн олон улсын бага хурлаас баталсан Транзит тээврийг хөгжүүлэх иж арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг биелүүлэхэд шаардагдах алхмуудыг цаашид ч хийх болно гэдгээ Оросын Тал нотлов.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Оросын Холбооны Улсад халуун дотноор хүлээн авсанд Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч Д.А.Медведевт талархал илэрхийлээд түүнийг Монгол Улсад дахин айлчлахыг урив. Урилгыг талархан хүлээн авав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ
Ц.ЭЛБЭГДОРЖ

ОРОСЫН ХОЛБООНЫ
УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Д.А.МЕДВЕДЕВ

Москва хот, 2011 оны 5 дугаар сарын 31-ний өдөр